

Нийгмийн даатгалын санд 2019 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар нийт 699.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 111.5 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 514.4 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 828.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 252.3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 05 дугаар сард 699.2 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 155.1 тэрбум төгрөгөөр өсчээ.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 75.3% буюу 526.2 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 9.4% буюу 65.7 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 12.7% буюу 89.0 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 2.6% буюу 18.3 тэрбум төгрөг;


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2019 оны 05 дугаар сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 828.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 99.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 526.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 250.7 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 410.1 мянган иргэдийн тэтгэвэрт 749.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 75.9 хувь буюу 569.1 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 303.2 мянган иргэнд зарцуулсан байна.


Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Тэтгэмжийн даатгалын сан

Энэ оны 05 дугаар сард тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 89.6 мянган иргэнд 49.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн 35.7 тэрбум төгрөг буюу 72.0 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж эзэлж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 05 дугаар сард тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 5.8 мянган иргэнд 12.9 тэрбум төгрөгийг зарцуулав.


Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 05 дугаар сард 18.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 8.9 мянган хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 16.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 тэрбум төгрөгөөр, зарлага 3.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

05 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 157.8 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 94.7 хувь буюу 149.4 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 48.9 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.


Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /сая төг, өссөн дүнгээр/

	2018_05 сар	2019_05 сар	Зөрүү
Тахир дутуугийн	9 992.6	10 137.2	144.6
Тэжээгчээ алдсаны	1 363.6	1 129.5	-234.1
Тэтгэмж. төлбөрийн	316.8	1 290.6	973.8
Сувиллын	383.8	350.5	-33.3
Нийт дүн	12 056.8	12 907.8	851.0

Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /сая төгрөгөөр/



Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 05 дугаар сарын байдлаар нийт 11885.9 сая төгрөг төлөвлөснөөс 10168.7 сая төгрөг зарцуулж, 1717.2 сая төгрөг хэмнэсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.0% буюу 2951.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/

	2018_05 сар	2019_05 сар	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Цалингийн сан. нийгмийн даатгалын шимтгэл	5784.1	7917.7	2133.6	26.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1433.4	2251.0	817.6	36.3
Дүн	7217.5	10168.7	2951.2	29.0